



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/109

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 3.3.1.5, 3.3.5.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3.3.5.1, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн үнэлж дүгнэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын соёлын тэргүүний ажилтан дуучин С.Нэргүйн “Донж төгөлдөр” уран бүтээлийн тоглолтын зардалд 3.000.000 (гурван сая), Сэлэнгэ аймагт зохион байгуулагдах өсвөрийн шатарчдын Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг, тамирчдын зардалд 1.000.000 (нэг сая), Татварын хэлтэст 2018 оны үр дүнгийн урамшуулалын зардалд 9.350.000 (есөн сая гурван зуун тавин мянга), Бадминтоны 2019 оны өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээний зардалд 1.335.000 (нэг сая гурван зуун гучин таван мянга), Аялал жуулчлалын англи монгол толь бичгийн зардалд 2.618.000 (хоёр сая зургаан зуун арван найман мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээний зардал 17.303.000 (арван долоон сая гурван зуун гурван мянга) төгрөгийг үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100256